

**БАЙГАЛЬД ЗОРЧИХ, ЯВГАН АЯЛАХ
ЭРХИЙН ТУХАЙ**

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэдийн байгальд зорчих, явган аялах эрхийг хангахтай холбогдуулан газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгальд зорчих эрхийн тухай хууль тогтоомж

2.1.Байгальд зорчих, явган аялах эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай /Газрын ерөнхий хууль/, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Байгальд зорчигч, явган аялагчийн эрх

3.1.Иргэд хуулиар хориглоогүй бол ой, ой хамгааллын зурвас, амралт, сувилал, цэцэрлэгт хүрээлэн, спортын цогцолбор, наран шарлагын газар болон усан сан, гол мөрөн, нуурын мандал, эргээр чөлөөтэй зорчих, явган аялах эрхтэй.

3.2.Байгальд зорчих, явган аялах зорилгоор бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалахыг эрх бүхий байгууллагаас зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн газарт хохирол учруулахгүйгээр нэвтэрч, дайран өнгөрч болно.

4 дүгээр зүйл. Байгальд зорчигч, явган аялагчийн үүрэг

4.1.Иргэд байгальд зорчих, явган аялахдаа дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

4.1.1.газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлж, байгаль орчныг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх үйлдэл /эс үйлдэхүй/ гаргахгүй байх;

¹ Явган аялах гэдэг нь механикжсан тээврийн хэрэгсэл ашиглахгүй явганаар, дугуйгаар, морь буюу ердийн хөсгөөр зорчихыг хэлнэ.

4.1.2. хог хаях, ил зайдгай гал түлэх, тусгайлан гаргасан орц, гарцнаас өөр газраар нэвтрэх, шинээр зам, зөрөг гаргах, зэрлэг ан амьтны амьдрах орчинг сүйтгэхгүй байх;

4.1.3. оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, 24 цагаас дээш хугацаагаар отоглох, уламжлалт зан үйл, соёлын өвтэй холбоотой үйл ажиллагаанаас бусад олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах;

4.1.4. хориглосон тохиолдолд механикжсан тээврийн хэрэгсэл ашиглах.

5 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын эрх

5.1. Төрийн захиргааны байгууллага нь байгальд зорчих, явган аялах эрхийг дараах нөхцөлд хязгаарлах эрхтэй.

5.1.1. байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газрын хэв шинж, унаган төрхийг хадгалах, хамгаалах, экосистемийн хувьд эмзэг газрыг хамгаалах зорилгоор зорчих, явган аялахыг хориглох;

5.1.2. гал түймрийн эрсдэл, зэрлэг ан амьтдын үржилийн үеэр газраар дамжин өнгөрөх буюу зорчих, явган аялахыг хориглох;

5.1.3. тусгай зам гаргах, хог хаях цэг байгуулах,

6 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын үүрэг

6.1. Төрийн захиргааны төв байгууллага нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

6.1.1. иргэд, аж ахуйн нэгж байгууллагад газар олгохдоо иргэдийн байгальд зорчих, явган аялах эрхийг хангах зорилгоор тодорхой газруудад орц, гарц гаргах, тусгай тэмдэглэгээ хийх;

6.1.2. нэгэнт олгогдсон газруудад шинээр гарц, орц гаргах талаар газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нартай зөвшилцөн, нөхөн олговор олгох, өөрийн зардлаар гарц орц гаргах, аялагсдад зориулсан тусгай зам гаргах;

6.1.3. орц, гарцыг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн саналыг харгалзан тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

7 дугаар зүйл. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн эрх, үүрэг

7.1. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь энэхүү хуулийн 6.1.3-т заасны дагуу тогтоосон орц, гарцыг хааж, аливаа үл хөдлөх эд хөрөнгө, хаалт, хашаа барихгүй байх үүрэг хүлээнэ.

7.2. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө гарц, орцыг хааж үл хөдлөх эд хөрөнгө, хаалт, хашаа барьсан тохиолдолд буруутай этгээдийн зардлаар хамгийн боломжит ойрын зайд шинээр орц, гарц гаргана.

7.3. Энэхүү хуулийн 7.2-т заасны дагуу орц, гарц шинээр гаргах боломжгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийг зөрчиж барьсан үл хөдлөх эд хөрөнгө, хаалт, хашааг албадан чөлөөлж, орц гарцыг нээнэ.

8 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэх

8.1. Энэ хуулийн 4.1 дэх хэсгийг зөрчсөн этгээд байгаль орчинд учруулсан хохирол, түүнийг арилгах болон цаашид үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны экологи-эдийн засгийн үнэлгээ, аргачлалын дагуу тогтоосон хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

8.2. Уг хохирлыг өөрийн хүч хөрөнгөөр арилгах арга хэмжээ авах бөгөөд хэрэв мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол үүнтэй холбогдон гарсан зардлыг бүрэн хариуцна.

9 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2. Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

10.1. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БАЙГАЛЬД ЗОРЧИХ, ЯВГАН АЯЛАХ ЭРХИЙН ТАЛААР БУСАД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА

Тухайн улсын эрх зүйн тогтолцоо, түүхэн уламжлал, газар нутгийн хэмжээ, хүн амын тоо зэргээс шалтгаалан улсууд харилцан адилгүй зохицуулалттай байна.

Англи-саксоны эрх зүйн тогтолцоотой улсууд болох Англи, АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг улсуудын хувьд байгальд зорчих, явган аялах эрхийг харьцангуй хязгаарлагдмал хүрээнд авч үздэг байна. Учир нь эдгээр улсуудад газрын эзэнд өөрийн өмч, газраа хамгаалах онцгой эрх олгогдсон байдаг бөгөөд хувийн өмчлөлийн газраар дамжин өнгөрөх, түр буудаллах нь ихэнх улсын хувьд хууль бус гэж тооцогддог.

Харин Ром-Германы эрх зүйн тогтолцоотой улсууд, түүний дотор манай улстай газар нутаг, хүн амын тоо, уур амьсгал, түүхэн уламжлалын хувьд төстэй гэж хэлж болох Финланд, Исланд, Норвеги, Швед, Эстони, Латви, Австри, Швейцарь зэрэг Скандинавын улс орнуудад байгальд зорчих, явган аялах эрх олон зууны туршид бүрэлдэн тогтсон уламжлалд суурилсан байдаг. Эдгээр улсуудын уламжлал, түүх соёл, ахуй амьдрал нь байгальтай салшгүй байдагтай холбоотой. Энэ ч утгаараа байгальд зорчих, явган аялах эрхийг "хүн бүрийн эрх" гэж үзэж, заншлын болон хуулийн хэм хэмжээгээр зохицуулж ирсэн байна.

Олон улсын стандарт, хэм хэмжээ

Олон улсын санхүүгийн корпораци 8 багц бүхий "Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт"-ыг батлан, тус корпорациас санхүүжилт авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосон. Манай улсын хувьд ч хөрөнгө оруулалт татах, дэд бүтцийг хөгжүүлэх, томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд уг стандартыг мөрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

"Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт"-ын газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан 5 дахь багцад барилгын болон дэд бүтцийн төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд тухайн орон нутгийн түүх соёлын дурсгалт газар, тусгай хамгаалалттай газар, тахиж шүтэж ирсэн уул, бусад уламжлалт зан үйл хийдэг газарт иргэдийг саадгүй зорчих нөхцөл боломжоор хангах үүрэг хүлээх бөгөөд аюулгүй байдлыг хангасан, тусгай зориулалтын орц, гарч байгуулахыг үүрэг болгосон байдаг.

Финланд

Финланд улс хүн бүр эх орныхоо байгалийн сайхантай танилцахын зэрэгцээ өвөг дээдсийн түүх соёл, ахуй амьдралын салшгүй хэсэг болсон байгаль, уул усанд чөлөөтэй зорчих, явган аялах эрхтэй гэж үздэг. Энэ эрх нь Финлянд улсын иргэд төдийгүй тус улсад аялаж байгаа бүхий л хүмүүст хамаардаг.

Тус улсын газар нутгийн 75%-ийг ой мод бүхий уул, толгод эзэлдэг бөгөөд өмнөд болон баруун эргийн дагуу олон мянган нуур, арлууд бий. Эдгээр байгалийн өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт газруудад зорчих, явган аялах эрх нээлттэй боловч тус улсын Хойд туйл орчимын байгалийн тогтоц, экосистем эмзэг байдаг тул тодорхой төрлийн хязгаарлалт үйлчилдэг.

Норвеги

Газар нутаг том, хүн ам харьцангуй цөөн энэ улсын хувьд хориглосон тэмдэглэгээ хийгээгүй буюу хашаа бариагүй бүх газраар дамжин өнгөрөх эрх нээлттэй байдаг. Гэсэн хэдий ч зарим нэг хязгаарлалт үйлчилдэг. Тухайлбал байгальд зорчигсад, явган аялагчид отоглон буудаллах бол тухайн газарт 24 цагаас хэтрэхгүй бөгөөд хамгийн ойр байрлах байшин, сууцнаас 150 метрээс багагүй буудаллахыг шаарддаг. Хэрэв 24 цагаас дээш хугацаагаар отоглон буух бол газар эзэмшигчээс зөвшөөрөл авах шаардлагатай. Түүнчлэн жил бүрийн 4 дүгээр сарын 15-аас 9 дүгээр сарын 15-ны хооронд ойн бүсэд ил гал гарахыг хориглодог.

Далайн эрэг дагуу газар эзэмших зөвшөөрөл авч, байшин барилга барих бол эрэг дагуу тусгай зурвас гаргаж иргэдийн аялах, зугаалах, зорчих эрхийг хангасан байхыг шаарддаг. Иймд Норвеги улсад далайн эрэг дагуу хашаа, хаалт барихыг хориглодог. Газар нутгийн тодорхой хувийг ус, усан сан эзэлдэг учраас гол мөрөн, нуур, далай зэрэг цэнгэг устай газруудад сэлүүрт болон далбаат завь зэрэг дуу чимээ гаргадаггүй, энгийн завиар явахыг зөвшөөрдөг бол давстай нууруудад моторт завиар явахыг зөвшөөрдөг. Аялагсад ан агнах, загас барих эрхгүй бөгөөд агнуур хийх, загас барих бол тухайн газрын эзэнд хамаардаг.

Швейцарь

Швейцарь улсад байгальд зорчих, явган аялах эрхийг тус улсын Иргэний хуулиар баталгаажуулж өгсөн байдаг. Байгальд аялах, зорчих эрхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг кантон (муж)-ууд өөрийн онцлогт тааруулан өөр өөрөөр тусгасан байдаг.

Швейцарь улс нь байгалийн үзэсгэлэнт, онгон зэрлэг байгаль бүхий газар нутгуудад хашаа барихыг хуулиар хориглосон байдаг. Зөвхөн экологийн хувьд эмзэг, шинэ залуу ой үүсэн бий болж байгаа болон биологийн ховордсон төрөл зүйлийг хамгаалах зайлшгүй шаардлагатай нөхцөлд хашаа барихыг зөвшөөрдөг. Хашаатай холбоотой энэ зохицуулалт нь хувийн өмчлөлийн газарт ч адил үйлчилдэг. Бусад улсуудын нэг адил байгальд зорчих эрхийг явган аялах эрх гэж авч үздэг учраас тээврийн хэрэгслээр зорчихыг хориглосон зохицуулалт байдаг.

Эстони

Эстони улсад байгальд явганаар, унадаг дугуйгаар, цанаар, завиар, морьтой аялахыг зөвшөөрдөг. Ерөнхий зохицуулалтын хувьд аялагч нь хувийн эзэмшлийн газраар дамжин өнгөрөхийг зөвшөөрдөг бөгөөд газар эзэмшигч нь өөрийн эзэмшлийн газраар дамжин өнгөрөхөд зөвшөөрөл авах шаардлагатай гэж үзвэл тусгай тэмдэг, тэмдэглэгээ, холбоо барих утасны дугаарыг тавьдаг.

Эстони улсад нийтийн эзэмшлийн буюу нийтийн хэрэгцээнд зориулагдсан бүх усан сан бүхий газруудын эрэг дагуу олон нийтийг зорчиход зориулсан 4 м хүртэлх өргөнтэй зурвас гаргадаг. Энэ зохицуулалт нь ундны усны эх бүрдэх газар, хувийн загасны аж ахуйн болон улсаас хамгаалалтанд авсан нуур, цөөрмийн хувьд үйлчлэхгүй.

Байгальд зорчих, явган аялах эрхтэй холбоотой зохицуулалтыг “хувь хүнд” илүү хамаарна гэж үздэг учраас олон нийтийн арга хэмжээ, ашгийн төлөө үйл

ажиллагаа явуулах нөхцөлд газар эзэмшигч болон орон нутгийн засаг захиргаанаас зөвшөөрөл авахыг шаарддаг.

Байгальд зорчигсдод, явган аялагчид тусгайлан барьсан хашаа, тариалангийн талбайд нэвтрэх, газар өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр гал асаах, буудаллах, ан агнуур хийх, мод, бут гэмтээх, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх, хориглосон тохиолдолд тээврийн хэрэгсэл ашиглах, байгаль орчныг бохирдуулахыг тус тус хориглодог.

Швед

Шведэд *allemansrätten* ("хүн бүрийн эрх") нь Шведийн Үндсэн хуулиар олгогдсон байгальд чөлөөтэй зорчих, явган аялах эрх юм. 1994 оноос хойш Засгийн газрын баталсан журмуудаар өмчлөх эрхийг үл харгалзан "хүн бүр байгальд аялах, зорчих эрхтэй" бөгөөд газар эзэмшигч нь уг эрхийг хангах үүрэгтэй гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл уг эрх нь хувийн цэцэрлэгт хүрээлэн, орон сууцны ойр орчмын газар, тариалангийн талбайг эс тооцвол дурын газраар дамжин өнгөрөх, алхах, дугуй унах, цанаар гулгах эрх нээлттэй гэж үздэг. Байгалийн нөөц болон бусад тусгай хамгаалалттай газар нутагт чөлөөтэй зорчих, явган аялах эрхийн хязгаарлалт үйлчилнэ.

Түүнчлэн далайн эргийн дагуу явган аялахыг зөвшөөрдөг. Эргийн дагуу аялах, зорчих зурвас тогтоож өгсөн бөгөөд эргийн дагуу 70 метрийн зоон тогтоож өгсөн байдаг бөгөөд 1975 оноос далайн эрэг, эргийн шугамаас ойр 100 метрийн зайнд шинэ байшин, барилга барихыг хориглосон зохицуулалт үйлчилж эхэлсэн.

Исланд

Скандинавын бусад орнуудын нэгэн адил Исландад байгальд зорчих, явган аялах эрхийг хуулиар баталгаажуулж өгсөн байдаг. Төрийн өмчийн газар, тухайлбал хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар нь хүн бүрт нээлттэй байдаг боловч зэрлэг амьтдын үржлийн үед, шинээр үүсч байгаа ой, ургамлын үр хаях зэрэг тодорхой хугацаанд байгальд зорчих, явган аялах эрхийг хязгаарласан зохицуулалт үйлчилдэг.

Явган аялагчид хамгаалалтын бүсэд тогтоосон дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. Байгалийн унаган төрхийг хамгаалах зорилгоор тусгайлан зам гаргасан бол уг замаас өөр газраар явах, шинэ зам гаргахыг хориглодог. Явган аялагчид нуур, цөөрмөөс загас барихад зөвшөөрөл авах бөгөөд нийтийн эзэмшлийн талбайд ургасан жимс, мөөг, далайн ургамал түүж хэрэглэхийг зөвшөөрдөг.